

СҮХБААТАР АЙМГИЙН ДАРЬГАНГА СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2022 оны 10 дугаар сарын мэдээлэл

2022.10.24.

“Овоот”

**Нэг. ТӨРИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР.**

-2022.10.01 ний өдөр “Ахмадын өдөр”-ийг тэмдэглэн, нийт 230 ахмадад хүндэтгэл үзүүлсэн. Энэ үеэр Ахмадын хорооны дарга Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлж гаргасан “Архиар дайлахгүй анхны сум болох” уриалгыг бүх нийтэд танилцуулж залуу хойч үедээ үлгэр дууриалал болгохоор ажиллаж байна.

Сумын Засаг дарга сумын Ахмадын хорооны үйл ажиллагааг дэмжиж иж бүрэн компьютерыг гардуулж өглөө.

-Сумын ИТХ-ын дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, Хамтарсан баг, ЕБС-ийн захиргаа хамтран 2022.10.07 нд “ХҮҮХДИЙН ХӨГЖИЛД-БИД ДЭМЖЬЕ-ШИЙДЬЕ” III чуулганыг амжилттай зохион байгуулж 130 хүүхэд оролцож, **“Бие биедээ хүндэтгэлтэй эрх тэгш хандаж, эерэг хандлагыг түгээж, эерэг ирээдүйг бүтээцгээе”** уриалгаа дэвшүүллээ.

-Сумын ИТХ-ын хороодын дарга нарын хурлыг 2022.10.17 нд зохион байгуулж, хорооны ажлыг эрчимжүүлэх чиглэл өгсөн.

-Намрын ээлжит цэрэг татлагын ажлыг аймаг, суманд амжилттай зохион байгуулж нийт 7 цэрэг шинээр албанд татагдлаа.

-Сумын ЗДТГ-т ЦАХИМААР цаг бүртгэл хийгдэж эхэлсэн. (Албан хаагч утсаараа Тамгын газрын коридорт байршуулсан кодыг уншуулж байна.)

**-Хууль эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын чиглэлээр**

-Төр хувийн хэвшлийн түншлэл, харилцааг бэхжүүлэх зорилгоор УБ хотын “Хүний эрх хөгжил төв” ТББ-тай хамтран сумын ЗДТГ, Ахмадын хороо, Эмэгтэйчүүдийн зөвлөл, Мөнгөн хуримтлалын бүлгүүдийн төлөөлөл оролцсон 31 хүний бүрэлдэхүүнтэй “ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХӨГЖҮҮЛЬЕ” сэдэвт хэлэлцүүлэгт сургалтыг “Хүний эрх”, Иргэний орон зай” сэдвээр 2022.10.17 ноос 18 ны өдөр зохион байгуулж 4 уриалга гаргаж, сумын ИТХ, Засаг дарга нарт өргөх бичгээр хүргүүлж, хамтран ажиллахаар боллоо. Үүнд:

1. Хүнсний эрүүл ахуй, хадгалалт, хамгаалалтад тавих хяналт шалгалтын ажлыг тогтмолжуулах.

2. Сумын төвийн “А” бүсээс мал, тэжээвэр амьтдыг чөлөөлөх.

3. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглалтад тавих хяналт шаардлагыг өндөржүүлэх.

4. ОНХС-ийн хөрөнгөөр “Бойны цэг”-ийг байгуулах ажлыг зохион байгуулах.

2022.10.20 ны өдөр “Хууль эрх зүйн сургалт сурталчилгааны өдөрлөг” –ийг нээж, нээлттэй хаалганы өдөрлөг хэлбэрээр сурталчилгаа, сургалтыг зохион байгуулж байна.

### **Хоёр. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР**

-Хөдөө аж ахуйн чиглэлээр Сүхбаатар аймагт зохион байгуулагдсан “Малчдын зөвлөгөөн”-д малчдын төлөөлөл 5 хүн очиж оролцсон.

-31097 толгой үхэрт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин хийхээс одоогоор 25 % тай тарилга хийгдэж байна.

Сумын аюулгүйн нөөцөд 8000 боодол өвс нөөцлөхөөс 7000 боодол өвсийг татаж нөөцлөөд байна.

### **Гурав. СОЁЛ, БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР**

Багш нарын 56 дахь өдрийг тэмдэглэн баярын хурал, цэнгүүн зохион байгуулж шилдэг багш ажилчдыг шагнаж урамшууллаа. Багш нарын баярыг угтаж сумын Хүүхдийн цэцэрлэг нь Сүхбаатар аймгийн 2 дугаар цэцэрлэг, Онгон, Наран сумын цэцэрлэгүүдтэй хамтарч 1 өдрийн эко аялалыг зохион байгуулж “Хоггүй цэвэр аялацгаая” уриан дор амжилттай зохион байгуулж нийт 4 байгууллагын 100 ажилтан албан хаагч нар Өлзийт булгийн ойр орчмын хог хаягдлыг түүж цэвэрлэгээ хийсэн.

2022.10.21 нд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт хангагдаж, “Гангын чуулган, хунгийн баяр, баян намар үзэсгэлэнг хослуулан өв соёлоо дээдлэн дэлгэрүүлэх” арга хэмжээг Дарьганга хошууны сумдын оролцоотой Гангын хөвөөнд амжилттай зохион байгууллаа.

- Сүхбаатар аймгийн "НЭГДҮГЭЭРТ\_ХҮҮХЭД" VII чуулганд сумын Хүүхдийн төлөө зөвлөлийн дарга, Засаг дарга Д.Болдбаатар, сургуулийн нийгмийн ажилтан, сургуулийнхаа хүүхдүүдийн дуу хоолой болж 5 сурагч оролцож 1 сурагч нь аймгийн Хүүхдийн зөвлөлийн гишүүнээр сонгогдсон.

- “Сүхбаатарын Өнгө” сонины 5 жилийн ойд зориулсан“НАЙРГЫН ОРНЫ НАЙРАГЧ ХҮҮХДҮҮД” уран уншлагын наадмын 1 дүгээр шатанд Цэцэрлэгээс 43 хүүхэд, ЕБС-аас 63, нийт 106 хүүхэд амжилттай оролцож 2 дугаар шатанд оролцох хүүхдүүд шалгарч амжилттай оролцов.

-Цэцэрлэгийн захиргаанаас санаачлан хүүхдийн эцэг эхчүүдийн оролцоотойгоор “НАЙРСАГ НАМАР-2022” үзэсгэлэн худалдааг 7 номинациар зохион байгууллаа.

ҮЕ ТЭНГИЙХНИЙ ДЭЭРЭЛХЭЛТ- ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ САРЫН АЯН"-ыг сумын ЕБС-д амжилттай зохион байгуулж байна.

Охидын эрхийг хамгаалах Олон Улсын өдөр. буюу 10 дугаар сарын 11-ний өдрөөр ЕБС-ийн эмч, Нийгмийн ажилтан нар охидын эрхийн асуудлаар мэдээлэл хүргэн тэдний санал хүсэлтийг авч охидын эрхийн зөрчлийн талаар зөвлөгөө өгөх ажлыг эхлүүлээд байна.

#### "ЦАГДАА ТАНД ТУСАЛНА" ГАР ЗУРГИЙН УРАЛДААНЫГ

Сүхбаатар аймаг дахь Цагдаагийн газрын түүхт 80 жилийн ойг угтаж Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд 3 насны ангиллаар зохион байгуулж дүгнэлээ.

2022-2023 оны хичээлийн жилийн уламжлалт намрын "Спорт өдөрлөг" оновчтой буухиа шидэлт, морьтон хүүхдүүд, саадтай буухиа, хөгжимт дасгал, уулын оргил булаалдах төрлүүдээр анги нийтээр хамрагдаж амжилттай зохион байгуулагдлаа.

#### Дөрөв. Эрүүл мэндийн чиглэлээр

ЭМТ-өөс сумын ЕБС-ийн 7, 15 насны хүүхдүүдэд сахуу татрангийн вакциныг тарьж эхлээд байна. Мөн Хүүхдийн цэцэрлэгийн 2-3 настны ангийн хүүхдүүдэд урьдчилан сэргийлэх үзлэгийг 2 өдөрт зохион байгууллаа.

-УБ хотын "Монсей" шүдний эмнэлгийн эмч нарын үзлэгийг 2 өдөрт зохион байгуулж 1. Хүүхдийн шүдний цоорлоос урьдчилан сэргийлэх түрхлэг, шүд цоорлын эмчилгээ, шүд авалт 2. Эрүү нүүрний гажиг заслын зөвлөгөө 3. Хиймэл шүд хийх(Лаборатори төлбөрөөр) 131 хүнийг үнэ төлбөргүй хамрууллаа.

#### **Зургаа: Байгаль орчны чиглэлээр.**

Намрын мод тарих ажлаар 16 мянган модны нүх ухах ажлыг эхлүүлж одоогоор 4000 нүхийг ухаад байна. Мөн энэ ажилд аймгийн ХХҮГ-тай хамтран "Нийтийг хамарсан ажил" төслөөр 20 иргэнийг 10 хоног ажиллуулж, цалинжуулж байгаа.

СБ аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газраас зохион байгуулагдсан "Тогтвортой хөгжилд эко клубын оролцоо" төсөл шалгаруулах уралдаанд тус сумын ЕБС-ийн Т. Болортуяа багштай эко клубийнхэн 3-р байр эзлэн "Батламж 2'000'000 санхүүжилтын эрхээ гардан авлаа.

ЕБС-ийн 9-12-р ангийн сурагчдын дунд зохион байгуулагдсан **"Хогоо мөнгө болгоё - Модоо төгөл болгоё"**-сэдэвт гар зургийн уралдаанд ЕБС-ийн 11а ангийн сурагч М.Бэлгүүтэй 3-р байр эзэллээ.

МЭДЭЭЛЭЛ БИЧСЭН

МЭРГЭЖИЛТЭН

Д. МӨНХЗУЛ

ТАНИЛЦСАН

ЗАСАГ ДАРГА

Д. БОЛДБААТАР